

Д.Хүрэлмаа, эдийн засагч-хүн ам зүйч, эдийн засгийн магистр  
МУИС-ийн ХАССТ-ийн багш, судлаач

### **Монгол Улсын Хотжилт 1990-ээд онд**

*Хотжилт нь нийгмийн өргөн хүрээтэй асуудлуудын нэг билээ. Энэхүү бүтээлд судлаач хотжилтын үүсэл хөгжил, түүний хөгжлийн ерөнхий зүй тогтол, хэв маягийн талаар авч үзсэн бөгөөд 1990-ээд оноос хойшхи Монгол улсын хотжилтын байдал, өөрчлөлт хувьсал, түүний нийгэм, эдийн засгийн болон хүн ам зүйн шалтгаан, үр дагавар, хотжилтын үйл явцад нөлөөлөгч хүчин зүйлс зэргийг тодорхойлох судалгаа шинжилгээ хийжээ. Хотын хүн амын өсөлт өөрчлөлт, тэдгээрийн бүтэц, шинж байдлыг бүс нутгаар задлан шинжилснээс гадна жини индекс, Лоренцийн муруй зэргээр хотын хүн амын төвлөрлийн үзүүлэлтийг тооцон гаргажээ.*

*Судалгааны үр дүндээ үндэслэн хотжилтын сэдвээрх тулгамдаж буй асуудлууд, мөн хотжилтын асуудлыг судлахад тохиолдож байгаа зарим бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлон гаргаж, өөрийн дүгнэлтийг хийснээс гадна түүний зөрчилтэй талыг шийдвэрлэх санал, зөвлөмж бичжээ.*

Орчин үеийн хүн төрөлхтөний нийгэм нь олон мянган жилийн хөгжлийн явцад бүдүүлгээс хөгжингүй, энгийнээс нарийн нийлмэл байдал руу дэвшин хөгжсөөр иржээ. Энэхүү хөгжлийн явцад гарсан чухал өөрчлөлт бол хүмүүсийн нутагшилтын нийтлэг хэлбэр болох хот үүссэн явдал юм.

Ойролцоогоор 5-6 мянган жилийн тэртээ Тигр, Евфрат мөрний хөндий буюу Меспотимид, мөн Нил мөрний хөндийд хот үүссэн гэж үздэг. Тухайн үеийн эртний эдгээр хотууд тойрон хүрээлсэн хамгаалалтын хэрэмтэй бөгөөд төвд нь эрх баригчид, элитүүд, захаар нь энгийн иргэдүүд суурьшдаг байжээ. Хотыг энэ үед цэрэг дайны хамгаалалтын зориулалттайгаар барьж байсан бол капитализмын үеэс хотыг байгалийн баялгийг эзэмших болон аж үйлдвэржилтийн үр дүнд үүсгэн байгуулах болсон. Олон тооны аж үйлдвэрийн газар байгуулагдсанаар түүнд ажиллах ажилчдыг хөдөөнөөс хотод олноор суурьшуулсан нь хотын хүн амын өсөлтөд үлэмж нөлөөлжээ. Энэ үеэс хотжих үйл явц хүчтэй явагдаж ирсэн. Энэхүү хотжих үйл явц тухайн үеийн аж үйлдвэрийн тэргүүлэх орон болох Англид эхлэн явагдаж, хожим нь АНУ болон баруун Европын бусад оронд эрчимтэйгээр явагджээ.

*Хотжилт* гэж, нийгмийн хөгжилд хотын үзүүлэх нөлөө дээшилж, хотын соёл, амьдрал, хэв маяг хөдөөд дэлгэрэх үйл явцыг хэлдэг. Энэ утгаараа хотжилт нь зөвхөн аж үйлдвэржилтийн үед төдийгүй түүнээс ч өмнө явагдаж байсан билээ.

Хотуудын эрс өсөлттэй холбоотойгоор хотын мөн чанар, түүний хөгжлийн ерөнхий зүй тогтлыг илрүүлэх шаардлагатай болсон. Үүнтэй холбоотойгоор хотжилтын асуудлыг судлах судалгааны үндсэн оролдлого хандлагууд 1920-иод оноос АНУ-ын Чикагогийн их сургуульд бүрэлдэн бий болж, улмаар хотжилтыг судлах асуудал тус сургуульд үндэслэн судалгааны

тусгай салбар болж чадсан юм. Чикагогийн сургуулийн төлөөлөгчид болох Р.Маккензи, Р.Парк, Л.Вирт нарын эрдэмтэд хотын дүүргүүдэд олон тооны судалгаа явуулж үлэмж хэмжээний эмпирик баримт хуримтлуулсан. Үүндээ үндэслэн боловсруулсан онол нь хөдөөгийн амьдралын хэв маяг хотын амьдралын хэв маягаас ялгаатай гэсэн үзэл санаанд тулгуурласан байдаг. Мөн ийм үзэл санаа социологийн сонгодог төлөөлөгчид болох Ф.Теннис<sup>1</sup>, Э. Дюркгейм<sup>2</sup> нарын бүтээлд тусгагдсан байдаг.

Хотжилтын энэхүү үйл явц манай улсыг ч тойрон гарсангүй. ХХ зууны 2-р хагасаас нүүдлийн аж төрөх ёсноос суурьшлын аж төрөх ёс руу улам бүр лавшран орж суурин амьдралын сэтгэл зүйн дүр төрх бүрэлдэж эхэлсэн. 1940-өөд оноос манай оронд нэгдсэн төлөвлөгөөтэйгээр аж үйлдвэр, тээвэр, холбоо, барилга зэрэг аж ахуй байгуулахыг эрчимтэй, цогцолбороор зарим газарт хөгжүүлж, улмаар шинэ шинэ хот суурингуудыг олноор нь байгуулж ирлээ.

Чухамхүү энэ үеэс Монгол Улсад хотжих үйл явц эхэлсэн. Үйлдвэрийн төв суурингууд олноор байгуулагдсанаар хөдөөнөөс хотод шилжин суурьшигчдын тоо эрс нэмэгджээ. Энэ үзэгдэл улсын нийслэл Улаанбаатар хотод илүү хурдацтай явагдаж байна. 1956 онд хөдөөгийн хүн ам, хотын хүн амаас 3.6 дахин их байсан бол хамгийн сүүлийн 2000 оны тооллогын мэдээгээр хот сууринд 1344.5 мянган хүн, хөдөө нутагт 1.029.0 мянган хүн ам суурьшиж байна. Эндээс харахад хотжих үйл явц бүх хот сууринд ижил биш, зөвхөн Улаанбаатар хотод эрс хүчтэй явагдаж байгаа учир Монгол Улс нийт хүн амынхаа гуравны нэг нь нийслэлдээ суурьшдаг дэлхийн цөөхөн улсын нэг болжээ. Хотын хүн амын өсөлтөнд шилжих хөдөлгөөн ихээхэн нөлөө үзүүлж байгаа нь сүүлийн үеийн судалгаа, шинжилгээний ажлаас тодорхой харагдаж байгаа билээ. Төвлөрсөн төлөвлөгөөт бодлого үгүй болж, Монголын нийгмийг хамарсан улс төр, эдийн засаг, нийгэм, оюун санааны өөрчлөлттэй холбоотойгоор хүн амын ихэнх нь хот  $\leftrightarrow$  хөдөө гэсэн тэнцвэрт харьцаанд биш, харин хөдөө  $\rightarrow$  хот гэсэн дан ганц урсгал бий болсон. Хүн амын хэт бөөгнөрөл, ядуурал, ажилгүйдэл зэрэг зайлшгүй учир шалтгааныг нь тодруулан судлах шаардлагатай олон тооны нийгмийн асуудлууд үүсч байна.

### **1990 оноос хойшхи хотжилтын байдал**

1990-ээд оноос эхлэн Монгол улс нийгэм, эдийн засаг, улс төрийн шинэ тогтолцоонд шилжиж нийгэм, хувь хүмүүсийн амьдралд ихээхэн өөрчлөлт орсон билээ. Үүнтэй уялдаад хотжилтын процесст, нэн ялангуяа, хотын хүн амын өсөлт, хотжилтын үйл явцад нөлөөлөгч хүчин зүйлс урьд өмнөхөөс өөр болсон билээ. Зураг 1-д сүүлийн 10 жилийн хотын хүн амын хувь хэрхэн өөрчлөгдсөн чиг хандлагыг харуулав.

<sup>1</sup> Ф.Теннис, Нийтлэг ба нийгэм

<sup>2</sup> Э. Дюркгейм Механик ба органик нэгдэл



Эх үүсвэр: ҮСГ, 2001. МУ-ын статистикийн эмхтгэл.

Дээрх зургаас харахад 1990 оноос хойш хотын хүн амын хувийн жин буурсан нь өмч хувьчлал өргөн хүрээтэй явагдсантай шууд холбоотой гэж болно. Энэ ажлын хүрээнд малчид малаа хувьчлан авч өөрийн хувийн хөрөнгөтэй болж эхлэсэн үе билээ. Ийнхүү хүн ам малаа даган хөдөө орон нутаг руу тэмүүлэх зүй ёсны үзэгдэл ажиглагдсан юм. Харин 1998 оноос хотын хүн амын тоо огцом өссөн байна.

Сүүлийн 2-3 арван жилд Монгол Улс улам бүр хотжих шинж чанартай болж, хотжилт нэмэгдсээр байна. Бусад улс орны нэг адил Монгол Улс хөдөө аж ахуйгаас үйлдвэржилт рүү шилжих явцын улмаас нийслэл хот болон бусад томоохон хот, суурин газрын хөгжиж байгаа нь хүн амын суурьшилтад хүчтэй нөлөө үзүүлэв. Эдгээр хот, суурин газар нь эрүүл мэнд, боловсрол болон бусад үйлчилгээ, хамгийн гол нь ажлын байр бий болгох төв болж, бусад газраас хүмүүсийг татаж, хотжилтын үйл явцыг улам бүр өргөжүүлсээр байна.

Аймгууд хотжилтын түвшний хувьд өөр хоорондоо нилээд ялгаатай байна. Хотын дэд бүтэц, жишээлбэл янз бүрийн түвшний сургууль, үйлдвэр, харилцаа холбоо аймагт илүү хөгжиж, тооллого хоорондын хугацаанд шилжигсдийн сонирхолыг татаж, аймгийн хүн амд хотын хүн амын эзлэх хувийн жинг өсгөжээ. Хотжилт хамгийн өндөртэй аймгуудад төмөр замын дагуу Орхон, Дархан-Уул, Говьсүмбэр, Сэлэнгэ, Дорнод аймгууд орж байгаа бөгөөд 2000 оны байдлаар эдгээр аймгийн хүн амын талаас илүү хувь нь хотод амьдарч, хотжих үйл явц үргэлжилж байгааг харуулж байна. Зураг 2-т Монгол Улсын хот, хөдөөгийн хүн амыг аймаг, нийслэлээр харуулсан болно.



Эх үүсвэр: ҮСГ, 2001. МУ-ын статистикийн эмхтгэл.

40000-с дээш хүн амтай дөрвөн хотод 2000 оны байдлаар нийтдээ 936 мянган хүн буюу нийт хүн амын 39 хувь нь амьдарч байна.

Хотын хүн амын суурьшилтыг бүс нутгийн ялгавартай байдлаар авч үзэхэд (хүснэгт 1) хэдийгээр хүн амын суурьшилт сийрэг, цөөн хүн амтай боловч Зүүн бүс нутаг нь Улаанбаатар хотын зэрэгцээ хотжилт хамгийн өндөртэй бүс нутаг болж байна. Баруун бүс нутаг харьцангуй олон хүн амтай, суурьшлын хувьд тийм сийрэг биш ч гэсэн хотжилтын түвшнээр хамгийн доогуур байна. Төвийн бүс болон Өмнөд бүс нутаг хүн амын тоо болон суурьшлын төрхөөрөө өөр хоорондоо адилгүй ч, хотжилтын түвшингээрээ адил байна.

Хүснэгт 1. Хот, хөдөөгийн хүн ам, бүс нутгаар, 2000 он

Бүс нутаг	Хот			Хөдөө	
	Хот, тосгоны тоо	Хүн ам, /мян.хүн/	Хувийн жин	Хүн ам, /мян.хүн/	Хувийн жин
Бүгд	<b>44</b>	<b>1344.5</b>	<b>56.6</b>	<b>1029.0</b>	<b>43.4</b>
Төв	16	929.0	39.3	451.3	60.7
Зүүн	8	84.7	41.8	117.8	58.2
Баруун	12	144.8	28.6	361.6	71.4
Өмнөд	7	62.9	39.0	98.3	61.0
Улаанбаатар	1	760.1	100.0	-	-


Эх үүсвэр: ҮСГ, 2001. МУ-ын статистикийн эмхтгэл.

Хотын хүн амын дийлэнх нь Улаанбаатар хотод (56.5%) суурьшин амьдарч байгаа бөгөөд энэ үзүүлэлтээр Төв болон Баруун бүсийн нутаг Улаанбаатарын дараа орж байна (Зураг 3).



Эх үүсвэр: ҮСГ, 2001. МУ-ын статистикийн эмхтгэл.

Монголын хотын хүн ам ерөнхийдөө нийслэл Улаанбаатар хотод ихээхэн төвлөрсөн байгаа нь дээрх жишээ, тайлбараас тодорхой харагдаж байна. Ийнхүү хэт их хүн нэг газар бөөгнөрөх нь хүн амын тархалт, суурьшилт, улмаар нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин, экологид сөрөг нөлөөллийг үзүүлсээр байдаг. 2000 оны тооллогын тоо мэдээг үндэслэн хотын хүн амын төвлөрлийг Лоренцын муруй, Жини индексээр тооцож үзье. (Зураг 4, Хүснэгт 2.)



Эх үүсвэр: ҮСГ, 2001. МУ-ын статистикийн эмхтгэл.

Хүснэгт 2. Хотын хүн амын төвлөрлийн Жини индекс, 2000 он

	Хотын хүн ам	хотын тоо	Харьцаа		өсөн нэмэгдэх давтамж	
			хүн ам (x)	хотын тоо (y)	x	y
10000<	44496	21	0.033094	0.477273	0.033094	0.477273
10000-19999	181929	12	0.135312	0.272727	0.168406	0.75
20000-49999	223913	8	0.166538	0.181818	0.334944	0.931818
50000-99999	134101	2	0.099739	0.045455	0.434683	0.977273
100000+	760077	1	0.565316	0.022727	1	1
	1344516	44	1	1		

$$G_i = \sum X_i Y_{i+1} - \sum X_{i+1} Y_i = 0.9438 - 1.7139 = 0.7701$$


Ийнхүү хотын хүн амын төвлөрлийг тооцож үзэхэд Жини индекс 0.77 гарсан нь төвлөрөл өндөр байгааг харуулж байна. Тэмдэглэж хэлэхэд, Монгол улсын хотжилтын нэг онцлог тал бол хотын хүн амын дийлэнх нь нийслэл Улаанбаатар хотод төвлөрч байгаа явдал юм.

Нийслэл хотын хүн амын нас хүйсийн бүтцийн өөрчлөлтийг сүүлийн 4 тооллогын дүнгээр хүн амын суварга ашиглан 5-7 дугаар Зурагнуудад харуулав.


Улаанбаатар хотын хүн амын нас, хүйсний суваргыг харахад 1969 оны байдлаар нийслэлийн хүн амын нас, хүйсний бүтэц харьцангуй жигд, зөв пирамид хэлбэртэй байна. Гагцхүү 25-29 насны эрэгтэй хүн амын хувийн жин нилээд огцом их байгаа нь насны алдаатай мэдээллийг гэрчилж болох юм. 1979 оны суваргатай харьцуулж үзэхэд 1979 оны суварга хэлбэрийн хувьд нилээд зөв өөрөөр хэлбэл, хүн амын нас, хүйсний тархалт харьцангуй жигд байгаа бөгөөд пирамид зөв хэлбэртэй байна. Бүх насны бүлэгт хүн амын хувийн жин өссөн нь зурагнаас тодорхой харагдаж байгаа юм. 10-24 насны эрэгтэй, эмэгтэй аль ч хүн амын хувийн жин нилээд хэмжээгээр өссөн бөгөөд энэ нь өмнөх үеийн төрөлтийн өндөр түвшнээр тайлбарлагдаж болох юм. Нэн ялангуяа 15-19, 20-24 насанд хүн амын тоо, хэмжээ аль ч хүйсийн хувьд нилээд өссөн нь залуучууд сургууль, соёлд суралцахаар хотод шилжин ирдэгтэй холбоотой байж болно.

1979, 1989 оны хүн амын суваргыг харьцуулахад мөн л бүх насны бүлэгт хүн амын тоо, хувь нэмэгдсэн байна. Суваргын суурь болох 0-4 насны хүүхдүүдийн талбай нилээд өргөн байгаа нь өмнөх жилүүдийн төрөлтийн түвшнээс хамаарч байгаа юм. Түүнчлэн, хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин нилээд их хэмжээгээр нэмэгдсэн нь шилжих хөдөлгөөний нөлөө багагүй байгааг нотолж байна.


Зураг 5. Улаанбаатар хотын хүн амын нас, хүйсийн суварга, 1969, 1979 он



Зураг 6. Улаанбаатар хотын хүн амын нас, хүйсийн суварга, 1979, 1989 он



Зураг 7. Улаанбаатар хотын хүн амын нас, хүйсийн суварга, 1989, 2000 он



1989 болон 2000 оны тооллогын мэдээнд үндэслэсэн Улаанбаатар хотын суварга нь ерөнхийдөө нийслэл хотын хүн ам хүйсийн хувьд харьцангуй тэгш, насны бүлгийн хувьд хөдөлмөрийн насны хүн ам, тэр дундаа 15-39 насны залуучууд давамгайлж байгааг харуулж байна. Ердийн өсөлтөөс гадна үүнд шилжих хөдөлгөөн ихээхэн нөлөөлсөн гэдгийг мөн харж болно. Онцлож тэмдэглэхэд, төрөлтийн түвшин мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан байдал суваргын суурьнаас харагдаж байна.

Хүснэгт 3-т Улаанбаатар хотын хүн амын ердийн болон механик хөдөлгөөнийг харуулав.

Хүснэгт 3. Улаанбаатар хотын хүн ам, ердийн болон шилжих хөдөлгөөн, 1991-2000 он.

Он	Хүн ам (мян. хүн)	Төрсөн	Нас барсан	Ердийн цэвэр өсөлт	Шилжин ирсэн	Шилжин явсан	Цэвэр шилжилт
1991	575,0	14979	4743	10236	5109	6815	-1709
1992	578,9	13485	5230	8255	7439	6327	1112
1993	589,0	9781	5258	4523	11634	3194	8440
1994	598,6	10928	4829	6099	12336	2789	9547
1995	609,9	11332	5114	6218	14648	2749	11899
1996	626,5	11263	5023	6240	7446	1296	6150
1997	637,4	10459	5016	5443	8493	1171	7322
1998	645,3	10531	4559	5972	15994	1195	14799
1999	693,8	12211	4659	7552	15199	822	14377
2000	778,7	11771	5037	6734	19910	592	19318

Эх үүсвэр: ҮСГ, 2001. МУ-ын статистикийн эмхтгэл.

Дээрх хүснэгтээс үзэхэд Улаанбаатар хотын хүн амын тоо тогтвортой өссөн байна. Ерөнхийдөө Улаанбаатар хотын хүн амын өсөлтөд шилжих хөдөлгөөн голлох үүрэг гүйцэтгэж байгаа нь тодорхой байна.

Гэхдээ ердийн өсөлтийн нөлөөлөл ч мөн их байгаа юм. 1990 оноос хойш төрөлтийн түвшин буурсан явдал нь хэд хэдэн шалтгаантай. Юуны өмнө энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжил зогсонги байдалд орсон, зах зээлийн эдийн засагт шилжих явдал эхлэж байсан бөгөөд хүн амын амьжиргааны түвшин доройтсоноос шалтгаалсан. Түүнчлэн эдийн засгийн шинэ харилцаанд орсон явдал нь бусад орнуудтай гадаад харилцаагаа хөгжүүлэх өргөн боломжийг нээсэн. Улмаар мэдээллийн цар хүрээ нэмэгдэж жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх хэрэгслийн талаар хүн амын мэдлэг дээшилсэн бөгөөд түүний хэрэглээ болон нийлүүлэлт өссөнтэй холбоотой юм. Мөн гадаад харилцаа хөгжихийн хирээр хүмүүс, тэр дундаа эмэгтэйчүүд боловсролынхоо түвшинг дээшлүүлэх хүсэл эрмэлзэл нэмэгдсэн нь төрөлтийн түвшинд зохих нөлөө үзүүлсэн гэж үзэж байна. Үүнээс гадна үр хөндөлт чөлөөтэй болсон нь төрөлтийн түвшинг бууруулахад нөлөөлсөн. 1994 оноос эхлэн төрөлтийн түвшин аажмаар өсч эхэлсэн нь нэн түрүүнд нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал харьцангуй тогтворжсонтой холбоотой.

Нас баралтын чиг хандлагын хувьд 1992-1993 онд өссөн. Нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн тогтолцоо өөрчлөгдсөнөөс бий болсон сөрөг талыг эрүүл мэндийн байгууллагууд ч тойрч гарсангүй. Энэ нь нас баралтын түвшин өсөхөд голлох нөлөөлөл үзүүлсэн байна. 1990 онд нас баралтын ерөнхий коэффициент 8.73 байхад 1993 онд 8.93 болов. Харин 1995 онд нас баралтын ерөнхий коэффициент 7.71 болтлоо буурчээ. Цаашид нас




баралтын түвшин буурах хандлагатай байгаа бөгөөд энэ нь хотын хүн амын өсөлтөд мөн нөлөөлөл үзүүлж байгаа юм.

Дээр нийслэлийн хүн амын өсөлтөд шилжих хөдөлгөөн голлон нөлөөлсөн гэдгийг дурдсан. Хүснэгтээс харахад цэвэр шилжилт жил ирэх тусам нэмэгдсээр байна. 1991 онд цэвэр шилжилт сөрөг гарсан нь тэр үед мал хувьчлал явагдаж эхэлсэнтэй холбоотой. 1992 оноос хойш мал хувьчлах үйл ажиллагаа үндсэндээ дуусч аажмаар хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөний урсгал эрчимжсэн байна. Мөн хот руу шилжих өөр нэг үндсэн шалтгаан бол хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа өндөр байгааг тэмдэглэх нь зүйтэй.

ХАССТ-ийн Дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгааны дүнгээс, хөдөөнөөс хот руу хүмүүс шилжиж байгаа хамгийн гол шалтгааны нэг бол ажил хайх явдал гэдэг нь тодорхой харагдаж байна. Шилжих хөдөлгөөн өндөр байгаа аймгуудад ажлын байрны хомсдол их, шилжигчдийн шилжсэний дараах ажил эрхлэлтийн түвшин шилжин ирэхээс өмнөх ажил эрхлэлтээс харьцангуй нэмэгджээ. Гэсэн хэдий ч шилжин суурьшсан нутгийн уугуул хүмүүстэй харьцуулахад ажил эрхлэлтийн түвшин доогуур байна. Мөн нийслэлд шилжин ирэгсэд богино хугацаанд ажилтай болох боломж харьцангуй бага байна.

Тус судалгаагаар уугуул нутгийн хүн амаас ганцаарчилсан асуулга авсан бөгөөд эдгээр нутагт Архангай, Дундговь, Увс, Хэнтий зэрэг аймгууд хамрагджээ. Уугуул нутгаас судалгаанд хамрагдсан хүн амын 30-50 хувь нь ажил эрхлээгүй бөгөөд шалтгааныг тодруулахад дийлэнх нь ажил хайгаад олдохгүй байна гэсэн хариулт өгсөн байна.



Эх үүсвэр: ХАССТ, 2001. МУ-ын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа.

### Дүгнэлт

Харьцангуй цөөн хүн амтай, нягтрал багатай Монгол улсын хувьд хүн амын байршил, суурьшлын асуудал нэн чухал асуудлуудын нэг болж байна. Хүн амын байршилтанд нөлөөлдөг нэг гол хүчин зүйл нь хүн амын хотжилт байдаг. Монголын хотжилтын үйл явцын чиг хандлага ерөнхийдөө дэлхий нийтийн улс орнуудын дамжсан үе шатуудтай ижил төстэй байгааг тэмдэглэх нь зүйтэй. Хотжилтын гол шалтгаан нь бусад орнуудын нэгэн адил аж үйлдвэржилтийн үйл явцын үр байлаа. Ялангуяа 1950-д оноос

хойш эдийн засаг, нийгмийн чухал өөрчлөлтүүд гарч ганц нүүдлийн мал аж ахуй дээр суурилсан эдийн засагтай орон байснаа аж үйлдвэр, суурин мал аж ахуй, газар тариалан дээр суурилсан эдийн засагтай орон руу аажмаар шилжиж эхэлжээ. Энэ үед Монголын хотжилтод аж үйлдвэржилт, нэгдэлжих хөдөлгөөн, хүн амын байршлын талаар төрөөс авч явуулсан бодлогууд ихээхэн үүрэг гүйцэтгэсэнийг дурьдах нь зүйтэй юм.

Түүнчлэн 1990-д оны эхэн үеэр Монголын нийгэм, улс төрд ихээхэн өөрчлөлтүүд гарч улмаар зах зээлийн харилцааны шинэ тогтолцоонд шилжих шилжилтийн үе эхэлсэн. Энэ үед хувьчлал тэр дундаа мал хувьчлал нь хүн амыг хөдөө орон нутагт татах хүчин зүйл болж билээ. Гэвч хүн ам амьжиргааны түвшин доогуур, нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал төдийгүй байгалийн жил дараалсан ган, зуд зэрэг байгалийн хүчин зүйл эрсдэл ихтэй мал аж ахуй эрхлэгчдэд ихээхэн бэрхшээлийн авчирсан юм. Энэ нь эргээд 1990 оны дунд үеэс эхлэн хүн амын хот руу чиглэсэн хүчтэй урсгалыг бий болгосон байна. Хамгийн сүүлийн хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харахад Монголын хүн амын 60 орчим хувь нь хотод амьдардаг бөгөөд үүнээс 57 хувь нь зөвхөн нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг. Энэхүү магистрын судалгааны ажилд 1990 оноос хойшхи, хотжилт эрчимжиж эхэлсэн үеийн байдлыг илүү нарийн судлахыг зорьсон. Харин хотжилтын талаарх мэдээ тайлангийн хангалтгүй байдлаас шалтгаалан зарим үзүүлэлт, шинжилгээг хийхэд хүндрэл гарсныг хэлэх нь зүйтэй болов уу. Манай оронд 1990-ээд оноос эхлэн нийгэм, эдийн засгийн шилжилтийн үе эхэлсэнтэй холбоотойгоор статистик мэдээлэлд өөрчлөлт орон ажилгүйдлийн түвшин, ажил эрхлэлтийн тоо, ядуурал, инфляцийн түвшин мэдээлэл гарч ирсэн билээ. Иймд дээрх мэдээлэл нь 1992 оноос хойшхи хугацаанд байгаа юм.

Түүнчлэн хотжилтын асуудлыг судлахад тохиолдож байгаа нэг гол бэрхшээл нь тодорхойлолтын асуудал юм. Манай улсын хувьд энэ нь нилээд төвөгтэй байсан бөгөөд энэхүү ажлаа бичихдээ Үндэсний статистикийн баримталдаг хотын тодорхойлолтыг авч хэрэглэсэн. Монгол Улсын хувьд “Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц нь хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн. Түүнчлэн “Тосгон нь 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн” гэжээ. Мөн Монгол Улсын Их Хурал 1994 онд аймаг, сум байгуулах, сум байгуулах, зарим хотын хороог татан буулгах, зарим хот, хороодыг сумдад нэгтгэх зэрэг тогтоолуудыг гаргасан. Эдгээр тогтоол нь 1993 оны “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуультай” зөрчилдөж байгааг анхаарах нь зүйтэй. Жишээ нь 1994 оны 5 сарын 6-ны өдөр баталсан Аймаг, сум байгуулах тухай 32 дугаар тогтоолд “Дархан хотын одоогийн хилийн цэсээр тодорхойлогдсон нутаг дэвсгэрт Дархан-Уул аймаг байгуулж, төвийг нь Дархан гэж нэрлэсүгэй” гэжээ. 83271 хүн амтай (2000 оны тооллогор), хүнд, хөнгөн үйлдвэртэй Дарханыг хот бус аймгийн төв гэх болсон байна. Ийнхүү бидний өмнө Дархан хот уу? аймгийн төв үү? Гэсэн асуулт гарч ирнэ. 1993 оны Хуулинд аймгийн төвийн хүн ам гэсэн ангилал тусгагдаагүй бөгөөд тус хуулинд зааснаар Дархан нь хот, түүний оршин оршин суугчид нь хотын хүн ам болох юм. Харин 1994 оны тогтоолоор Дархан нь Дархан-Уул аймгийн төв болсон юм. Хэдийгээр ийнхүү 21 аймаг

нэг хоттой болсон ч Үндэсний Статистикийн Газрын тоо, мэдээлэл засаг захиргааны нэгжүүдийг 1994 оны тогтоолын дагуу ангилж хотын хүн амаа 1993 оны Хуулийн дагуу тодорхойлсон байсан юм. Энэхүү зөрчлийг шийдвэрлэх дараах арга замыг санал болгож байна. Үүнд, 1993 оны Хуульд доорхи нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар санал гаргаж байна:

1. Монгол Улсын хүн амыг байршлаар нь хотын, тосгоны, хөдөөгийн хүн ам гэж ангилах,
2. Засаг захиргааны нэгжийн хувьд аймгийн төв гэж нэрлэж харин оршин суугчдыг нь хотын хүн амд тооцох,
3. Үйлдвэр, үйлчилгээний салбарт ажиллагсдын эзлэх хувийн жинг тодорхой зааж өгөх,
4. Хот бүрдүүлэгч дэд бүтэц гэдгийг тодорхойлж өгөх.

Монгол улсын хүн амын тархалт жигд бус байгаа бөгөөд нийслэлд ихээхэн төвлөрсөн байгаа нь шинжилгээний явцад харагдлаа. Нийслэл хотын хүн амын өсөлтөнд нөлөөлөгч хүн ам зүйн гол хүчин зүйлс нь ердийн болон шилжих хөдөлгөөний цэвэр өсөлт байсныг тодорхойлж гаргалаа. Ингэхдээ механик өсөлтийн нөлөөлөл их байгаа бөгөөд цаашид хотын тэр дундаа нийслэлийн хүн ам тогтвортой өсөх хандлагатай байгаа юм. Улс орны бүс нутгийг жигд хөгжүүлэхэд Монгол улсад хүн амын суурьшлын талаар асуудлыг онцгой анхаарах цаг нэгэнт болжээ. Үүнд:

- Бүс нутгаас гадагш шилжих хөдөлгөөнийг сааруулахын тулд энэ бүс нутгийг хөгжүүлэх асуудлаар яаралтай арга хэмжээ авах.
- Шилжин суурьшсан нутгуудад орон сууц, ажил эрхлэлт, бүх төрлийн үйлчилгээгээр хангах, малын бэлчээр, газар, устай холбоотой асуудлуудад анхаарах.
- Гадагшаа шилжих хөдөлгөөн өндөр бүс нутгуудыг сэргээн хөгжүүлэх, эдийн засгийг дэмжих, үүний зэрэгцээ шилжин ирж буй хүмүүсийн нийгэм, эдийн засгийн асуудлыг баталгаажуулах зэрэг асуудлуудад анхаарах нь зүйтэй байна.

## Ном зүй

---

1. С.Голдстейн ба Д.Сли, 1976. Хотжилтын загварууд: Олон улсуудыг зэрэгцүүлсэн судалгаа, Хүн амын судалгааны олон улсын эвсэл, Илтгэл 3.
2. УСГ, 1991. БНМАУ-ын эдийн засаг 70 жилд, УБ.
3. ҮСГ, Монгол улсын хүн ам, орон сууцны тооллогын үр дүн, 1969, 1979, 1989, 2000, УБ.
4. ҮСГ, 1999. МУ-ын статистикийн жилийн эмхтгэл, УБ.
5. Монгол улсын ШУА, Монголын мэдээлэл, (Оксфорд, 1990)
6. Ньюперт, 1992. Монголын хүн амын орчин үеийн хандлага, Ази, Номхон далайн орнуудын хүн ам, сэтгүүл, 1992
7. Азийн хөгжлийн банкны 1992 оны статистик мэдээ.
8. Бауден, 1968 болон Браун, Онон, 1976. Нэгдэлжих хөдөлгөөн болон түүний зарим үр дагавруудын талаар, УБ.

9. Б.Баясгалан, О.Сүхбаатар, 1992. Монголын шилжих хөдөлгөөний талаарх бодлого, УБ.
10. Ринауд, 1982. Хөгжиж буй орнуудын хотжилтын үндэсний бодлого, Нью-Йорк.
11. НҮБ, 1973. Хүн амын хандлагын шалтгаан болон үр дагаврууд, Нью-Йорк.
12. Х.Шриок, Ж.Сайгел, 1976. Хүн ам зүйн аргууд, Нью-Йорк.
13. Т.Мерик, 1986. Дэлхийн хүн амын шилжилт, Вашингтон.